

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн
тогтолцоо хангалтгүй байна.**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо,
төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д
хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОО-2021/14-10-ШТА-ГА

Чойбалсан хот 2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Дэлгэрмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
Аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Гэрээт аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА...	8
A.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт үр дүнтэй, бүрэн хэрэгжихгүй байнав.....	8
A.1.1 Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдаагүй	8
A.1.2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.....	9
A.1.3. Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зарим үндэсний хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.....	10
A.1.4.Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зарим журмууд батлагдаагүйгээс хуулийн заалтууд бүрэн хэрэгжихгүй байна.....	11
A.2 Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.....	12
A.2.1. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог бодлогоор зохицуулсан ч хэрэгжилт хангалтгүй байна.....	12
A.2.2. Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилсан байна.....	13
A.2.3. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтан гарч байна.....	14
A.2.4. Хүнсний аюулгүй байдал алдагдах онцгой нөхцөл байдал үүсэх үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.....	15
A.3. Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандарт, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдахгүй байна.....	16
A.3.1. Аймгийн хэмжээнд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын шийдвэрлэлт хангалтгүй, хүнсний тухай хуулийн 6.2, 6.3, 6.5 дахь заалтууд хэрэгжихгүй байна.....	16
A.3.2. Лабораторийн үйл ажиллагаа тогтмол ажиллаж байгаа хэдий ч тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хүчин чадал өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй байна.....	16
A.3.3. Аймгийн хэмжээнд хүнсний дотоодын болон импортын зохистой харьцаа хангагдахгүй байна.....	17
A.3.4. Импортлогч аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний стандартыг мөрдүүлэх, хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах замаар дотоодын үйлдвэрлэгчдэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	18
A.3.5. Хүнсний сүлжээний бүх үе шатны хяналт, баталгаажуулалтын тогтолцоо хэрэгжих шатанд, бүртгэл, мэдээллийн тогтолцоо орон нутгийн түвшинд бүрдээгүй байна.....	20
A.3.6. Аймгийн хэмжээнд шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байгаа бөгөөд орон нутгийн нийт зах зээлийг бүрэн хангахгүй байна.....	21
A.3.7. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна.....	25
A.3.8. Аймгийн хэмжээнд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар бодлогын түвшинд оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.....	27
БҮЛЭГ 2. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	28

Б.1 Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	28
Б.1.1. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.....	28
Б.1.2. Хүнсний салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.....	29
Б.1.3. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	30
Б.1.4. Аймгийн хүнсний салбарт батлагдсан дэд хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт хийгдсэн байна.....	32
Холбогдох байгууллагын санал:	
ДҮГНЭЛТ:	33
САНАЛ:	34
ЗӨВЛӨМЖ:	35
ТУШААЛ:	36

Товчилсон үгийн тайлбар

ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ДОА	Дорнод аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУ	Монгол Улс
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс, хөдөө, аж ахуйн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СХХ	Стандарт хэмжилзүйн хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
тн	тонн

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	“Лабораторийн хөрөнгө оруулалт 2017-2021”	16
Хүснэгт 2	“Импортын бүтээгдэхүүнд хяналт хэрэгжүүлдэг байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ”	18
Хүснэгт 3	“Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд хяналт хэрэгжүүлдэг байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ”	19
Хүснэгт 4	“Дорнод аймгийн хүн амын тоо”	22
Хүснэгт 5	“Дорнод аймгийн жишсэн хүн амын тоо”	22
Хүснэгт 6	“Жишсэн хүн амын хоногийн болон жилийн хүнсний хэрэгцээ”	23
Хүснэгт 7	“Дорнод аймгийн хэмжээнд гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн нийт нөөц, тн”	23
Хүснэгт 8	“Дорнод аймгийн хэмжээнд гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн хүнсний хангамж, хувиар”	24
Хүснэгт 9	“МХГ-ын 2018-2020 оны хяналт, шалгалтын судалгааны илэрц”	26
Хүснэгт 10	“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын гинжин хэлхээ”	26
Хүснэгт 11	“Дорнод аймгийн хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2019, 2020 он, 10000 хүн амд”	29
Хүснэгт 12	“Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд”	29
Хүснэгт 13	“Дорнод аймгийн хэмжээнд хорт хавдрын өвчлөл, нас баралт, 10000 хүн амд”	29

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“Сорьц, үзүүлэлтийн харьцуулсан шинжилгээ”	16
Дүрслэл 2	“Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжийн судалгаа”	17
Дүрслэл 3	“Дорнод аймгийн хэмжээнд 2019, 2020 оны жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, тн”	23
Дүрслэл 4	“Хүнсний аюулгүй байдлын схем”	28

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдэв, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх; 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж байгаа аймгийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллага, бүх шатны төрийн болон хувийн өмчийн лаборатори, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч байгууллага, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулна.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын А/69 тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан төлөвлөгөө, тайлан, судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Я.Зориг, С.Энхбаатар, гэрээт аудитор Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлүүлж, тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын аудитын Гуравдугаар газар болон аймгийн ИТХ, Засаг дарга нарт 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүргүүлээ.

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1.Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт үр дүнтэй, бүрэн хэрэгжихгүй байна.

1.1.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо нь УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан *"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"*, Дорнод аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан *"Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн"* үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан *"Хүнсний ногоо"* үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор баталсан *"Жимс жимсгэнэ"* үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан *"Сав, баглаа боодол"* үндэсний хөтөлбөр зэрэг төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хүрээнд зохицуулагдаж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хүнсний аюулгүй байдалтай холбоотой 17 заалтыг хэрэгжүүлэхээр тусгаж 2017 онд 30.0 хувьтай, 2018 онд 64.7 хувьтай, 2019 онд 74.7хувьтай, 2020 он 92.9 хувьтай тус тус аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт *"Жимс жимсгэнэ"*, *"Сав, баглаа боодол"*, *"Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн"* үндэсний хөтөлбөрүүдийн заалт 1-2 тусгагдсан нь хангалтгүй, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй, дэд хөтөлбөр батлагдаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд бүрэн тусгаж боловсруулаагүй, уялдуулаагүй байна.

1.1.2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Монгол Улсад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын харилцааг зохицуулж буй 644 стандарт байна. Үүнээс хүнсний үйлдвэрийн боловсруулалтын чиглэлээр 35, хүнсний бүтээгдэхүүний сорилт, шинжилгээний нийтлэг аргын 50, тариа буудай буурцаг тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний 101, жимс ногоо тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний нийтлэг асуудлын 21, жимс жимсээр хийсэн бүтээгдэхүүний 55, сүү, сүүн бүтээгдэхүүний 33, сүү, сүүн бүтээгдэхүүний 27, цөцгийн тосны 3, бяслагийн 3, зайрмаг, зайрмагтай амттаны 2, бусад сүүн бүтээгдэхүүний 7, амьтны гаралтай нийтлэг бүтээгдэхүүний асуудлын 52, гэрийн тэжээвэр шувуу ба өндөгний 4, загас загасан бүтээгдэхүүний 3, далайн лаазалсан хулд загасны 6, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүний 13, цай, какао, кофены 20, ундааны 49, үл согтууруулах ундааны 19, элсэн чихэр, элсэн чихрэн бүтээгдэхүүний 14, цардуул түүгээр хийсэн бүтээгдэхүүн 10, шоколадны 1, хүнсний тос ба өөх тосны үрийн 19, халуун ногоо ба хоол амтлагчийн 33, жижиглэсэн савласан ба бэлэн хүнс 6, мэдрэхүйн шинжийн 5, хүнсний бүтээгдэхүүний шууд харьцах материал ба зүйлийн 5, хүнсний үйлдвэрийн нэгж хэсэг ба тоног төхөөрөмжийн 4, зохицуулах үйлчилгээтэй хүнсний 44 стандарт тус тус хэрэгжиж байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зориулан хүнсний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:2016, Савласан хүнсний бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага MNS CAC 1:2007, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968:2000, савласан бүтээгдэхүүний тоон хэмжээ MNS OIML R 87:2008 зэрэг сэдвүүдээр сургалт зохион зохион байгуулж үйлдвэрлэл эрхлэгчдийг мэдээллээр ханган ажилласан байна.

Хүнсний чиглэлийн 14 стандарт 2021 онд шинээр батлагдсан байна. Монгол улсын стандарт нь заавал мөрдөх, сонгож хэрэглэх гэсэн 2 чиглэлээр байна.

Хүнсний чиглэлийн стандартуудын батлагдсан огноог авч үзэхэд 1960 -1970 онд 4, 1970- 1980 онд 33, 1980-1990 онд 86, 1990 -2000 онд 104, 2000-2021 онд 403, 2021 онд 14 батлагдсан байна. Үүнээс дүгнэхэд 35.2 хувь нь 1960-2000 онуудад батлагдсан байгаа нь техник, технологи хөгжихийн хэрээр стандартыг шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

"Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавих шаардлага MNS ISO 22000:2019" олон улсын стандартыг хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хэрэгжүүлэхэд урт хугацаа шаардсан, төсөв санхүүгийн зардал өндөр учир хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна. Хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулахын тулд бүтээгдэхүүний стандартын дагуу иргэн аж ахуйн нэгж нь өөрийн цех, үйлдвэртэй байх шаардлага тавигддаг. Цех, үйлдвэртэй газрууд бүтээгдэхүүнээ шинжлүүлсний дараа тохирлын гэрчилгээ авах нөхцөл бүрдэх байтал ихэнх иргэд гэрээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учир лабораторид шинжилгээ хийлгэхгүйгээр бүтээгдэхүүнээ худалдан борлуулж байна. Энэ нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Өнөөдрийн байдлаар MNS 2488:1998 Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4578:1998 Чанамал гурилан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага зэрэг стандартыг шинэчлэн батлах төсөлд санал авч байгаа боловч иргэд, аж ахуйн нэгж стандартын төсөлд саналаа өгөх нь хойрго байдаг нь мэдлэг дутмагаас шалтгаалж байна.

Олон улсын стандартыг нэвтрүүлэхэд сургагч багшийг бэлдэх шаардлагатай боловч төсөв хөрөнгө байхгүйгээс шийдэгддэггүй байна.

1.1.3 Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зарим үндэсний хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Засгийн газрын 2017 оны 89, 2020 оны 12 дугаар сарын 09-ний 206 дугаар тогтоолуудаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/159 дүгээр тушаалаар батлагдсан "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал" гэсэн баримт бичгүүдээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргах, үнэлэх асуудлыг зохицуулсан байна.

Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 5.4. "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" дэд хөтөлбөрийг баталж, санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжилтэд нь хяналт тавина.", 5.5. "Аймаг, нийслэлийн Засаг дарга "Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг жил

бүрийн 1 дүгээр сард хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу дэд хөтөлбөр батлагдаагүй, хэрэгжилтийг үндэсний хөтөлбөрийн хүрээнд тайлан хэлбэрээр гаргаж хүргүүлсэн.

Аймгийн ХХААГ-ын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан 2020 оны үр дүнгийн гэрээний 1.3.5.2-д “Хүнсний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулан батлуулна” гэж заасан боловч энэ ажлын хүрээнд “Эрүүл хүнс–Эрүүл Монгол хүн” дэд хөтөлбөрийн төслийг боловсруулах, иргэд, аж аж ахуйн нэгжийн саналыг авч тусгах хэлэлцүүлэг зохион байгуулаагүй шалтгаанаар хэрэгжээгүй гэж тайлбарласан байна.

Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөр боловсруулж батлуулсан байна.

Хүнсний ногоо дэд хөтөлбөрийн биелэлт ХХААГ 2018-2020 онуудад 100.0 хувь, аймгийн ЗДТГ 2020 онд 44.6 хувьтай дүгнэсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2022 онд дуусахаар байна.

Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор баталсан “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн 7.3. “Аймаг, нийслэлд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөл ажиллаж, дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх бөгөөд түүнийг тухайн шатны Засаг дарга ахалж, гишүүдэд орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл орж ажиллана.” гэсэн заалтын дагуу дэд хөтөлбөр батлагдаагүй, хэрэгжилтийг үндэсний хөтөлбөрийн хүрээнд тайлан хэлбэрээр гаргаж хүргүүлсэн.

Аймгийн ХХААГ-ын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний 7.13-д Засгийн газрын 2017 оны 223 дугаар тогтоолоор батлагдсан “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөр боловсруулж батлуулан хэрэгжүүлэхээр заасан боловч батлагдаагүй байна.

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолын 3-д “Хөтөлбөрийг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.” гэсэн заалтын дагуу дэд хөтөлбөр батлагдаагүй, хэрэгжилтийг үндэсний хөтөлбөрийн хүрээнд тайлан хэлбэрээр гаргаж хүргүүлсэн.

Аймгийн ХХААГ-ын даргын аймгийн Засаг даргатай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний 2.6-д “Сав баглаа боодол хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэлсэн байх” гэж тусгасан боловч батлагдаагүй байна.

Хөтөлбөрүүдийн биелэлт, хэрэгжүүлэх арга хэмжээнд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн талаар тусгаагүй байна.

1.1.4 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зарим журмууд батлагдаагүйгээс хуулийн заалтууд бүрэн хэрэгжихгүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо нь Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Органик хүнсний тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хүрээнд зохицуулагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зарим хуулийн заалтууд хэрэгжихгүй байна.

Тухайлбал:

Хүнсний тухай хуулийн 6.1-д “Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ.” гэж заасан байдаг. Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох мах, сүүний үнийн хэлбэлзэл хамгийн өндөр байдаг.

1. Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан. Улсын хэмжээнд 7 томоохон сүүний үйлдвэр тус шаардлагыг хангаж урамшуулал олгож байна. Тус журамд заасан үйлдвэр, цехэд тавих шаардлагыг хангасан үйлдвэр орон нутагт байхгүй учраас хэрэгжихгүй байна.
2. Хүнсний тухай хуулийн 6.2. “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.” гэсэн боловч батлагдаагүй байна.

Баяжуулсан хүнсний тухай хууль 2018 онд батлагдаж 2020 оноос хэрэгжиж эхэлсэн ч энэ хуулийн 5.2. “Энэ хуулийн 5.1-д заасан саналыг үндэслэн албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг Засгийн газар батална.” гэсэн боловч батлагдаагүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9.5. “Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн боловч батлагдаагүй байна.

Хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1.2 “Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлнэ”, 8 дугаар зүйл “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах”, 9 дүгээр зүйл “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл”, Хүнсний тухай хуулийн 12.1 “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.” гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй түвшинд байна.

Хүнсний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид нь тухайн чиглэлийн үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм, журмыг судалдаггүй, мэдлэг дутмаг байдал нөлөөлж байна.

Хүнсний үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн 40% орчим нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түрээслэгч, түрээслүүлэгч хоорондын гэрээ нь тодорхой бус, зарим нь гэрээ байгуулахгүй аман тохиролцооны дагуу түрээсэлдэг зэргээс шалтгаалж ажлын байрыг стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн өргөтгөх, өөрчлөн засварлахад хүндрэл гардаг, стандарт, эрүүл ахуйн шаардлагын түвшинд хүрч чадахгүй байна.

Иймд Хүнсний чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан түрээслэгч, түрээслүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан журам гаргах, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд тусгах шаардлагатай байна.

Нийгмийн цахим сүлжээ болон сошиалаар гэрээр үйлдвэрлэсэн болон хаана үйлдвэрлэсэн нь тодорхойгүй шинжилгээ баталгаагүй түргэн гэмтэж муудах хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн худалдах асуудал нэмэгдэж байна.

Нийгмийн цахим сүлжээ болон сошиалаар явуулдаг онлайн худалдааны талаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заалт оруулах, журам боловсруулж, хяналтын тогтолцоотой болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

1.2. Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

1.2.1. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог бодлогоор зохицуулсан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл хүнс – Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр 3.5.5. “хүнсний салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, хүнсний сүлжээнд зохистой дадлын сургалт зохион байгуулах зэрэг төрийн чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, их, дээд сургуульд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 3.3.6. “Дорнод аймагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний зах зээл, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэгчид, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.”, аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн 3.2.4.1. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг сан, төрийн бус байгууллагуудтай хамтран аж ахуйн нэгжүүдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна.” гэсэн заалтуудаар зохицуулсан байна.

Монголын Хүнсчдийн холбооны Дорнод аймаг дахь салбар зөвлөлөөс гарсан саналыг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган ажилладаг гэх боловч Коронавируст халдвар /covid-19/-ын цар тахал Монгол улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан сүүлийн 2 жил арга хэмжээ зохион байгуулагдаагүй байна.

1.2.2 Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилсан байна.

Аймгийн хэмжээнд Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Аймгийн ЗДТГ- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс- Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн-1- Үйлчилгээ, худалдаа, хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлого төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх;

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1- Хөдөө аж ахуйн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх

ХХААГ- Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний алба -Хүнсний үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн-1, Худалдаа, Хоол үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн-1, Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний алба -Хүнс, газар тариалангийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, төр засгийн

бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, сурталчлах, аймгийн төвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, орон нутгийн иргэд, хүнс, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид, засаг захиргааны байгууллагыг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулж, мэдээлэл түгээх, орон нутагт үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангуулах зорилготой.

ЭМГ- Нийгмийн эрүүл мэндийн төв -Хоол, тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн -1

МХГ- Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтэс -Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч-2, Таримал ургамлын үрийн хяналтын улсын байцаагч-1, Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч-1, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч-2, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч /орчны эрүүл ахуй/-1, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч /халдвар судлал/-1, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч /хүүхдийн эрүүл ахуй/-1, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч /хүнсний эрүүл ахуй/-1

Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс- Хилийн Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч-2 гэсэн бүтэцтэй ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын асуудал, сургалт, сурталчилгааны чиг үүргийг холбогдох хууль, журамтай харьцуулж үзэхэд төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг зохистой хуваарилсан байна гэж үзэж байна.

1.2.3 Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтан гарч байна.

Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчилд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт Зөрчлийн тухай хуулийн 6.14, 6.15, 6.17 дугаар зүйлд тусгагджээ.

Аймгийн хэмжээнд Мэргэжлийн хяналтын газар нь чиг үүргийнхээ хүрээнд хүнсний сүлжээний бүх үе шатанд хяналт шалгалтыг хийхдээ эрсдэлд суурилж, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийж байна.

Тус байгууллагаас ирүүлсэн хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн хяналт шалгалтын мэдээллээс үзэхэд 2018-2020 онуудад төлөвлөгөөт 385, төлөвлөгөөт бус 26, гүйцэтгэлийн 164, нийт 575 объектыг хяналт шалгалтад хамруулснаас төлөвлөгөөт шалгалтаар 4048, төлөвлөгөөт бус шалгалтаар 260, гүйцэтгэлийн шалгалтаар 1844, нийт хяналт шалгалтаар 6152 зөрчлийг илрүүлсэн байна. Уг хяналт шалгалтаар илрүүлсэн нийт зөрчлийн арилгуулсан байдлыг 2018-2020 он буюу 3 жилийн дунджаар авч үзэхэд төлөвлөгөөт шалгалтаар илрүүлсэн нийт зөрчлийн дунджаар 63.8 хувийг, төлөвлөгөөт бус шалгалтаар илрүүлсэн нийт зөрчлийн дунджаар 58.0 хувийг, гүйцэтгэлийн шалгалтаар илрүүлсэн нийт зөрчлийн дунджаар 65.3 хувийг тус тус арилгуулсан байна.

Хяналт шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн дийлэнх нь хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа хэтэрсэн, орчны эрүүл ахуй, стандарт, чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй, шошгын зөрчлүүд эзэлж байгаа бөгөөд үр дүнд нь эрсдэлийн түвшин тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан нь эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсоноос мэргэжлийн хяналтын

байгууллагаас хяналт шалгалтыг хийж, хариуцлагын арга хэмжээ авсан асуудал гараагүй байна.

Аймгийн төрийн байгууллагуудаас хүнсний аюулгүй байдалд хамаарах асуудлаар аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл, урлагийн газрууд хамтран 2018-2020 онуудад аймгийн төвийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар аюулгүй байдалд дэмжлэгт хяналт үнэлгээг 2-4 удаа хийж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан байна. Мөн хүнсний аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх чиглэлээр Мэргэжлийн хяналтын байгууллага нь 2018-2020 онд төрийн зарим байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийсэн байна.

Хүнсний аюулгүй байдалд тавих зохих хяналтыг Мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлж байгаа ч хяналт шалгалтаар илэрсэн зарим зөрчлүүд дахин давтан гарч байна. Тухайлбал: Хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах зохих стандарт шаардлага хангасан байргүй зөрчил гарч байна. Үүнээс болж хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд сөрөг үр дагавар үүсэж болзошгүй байна.

Иймд хүнсний аюулгүй байдлын чиглэлээр илэрсэн зөрчлийг засаж залруулах, давтан гаргуулахгүй байх талаарх үр дүнг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

1.2.4. Хүнсний аюулгүй байдал алдагдах онцгой нөхцөл байдал үүсэх үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангахад салбар дундын зохицуулалтыг тусгасан, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Гэтэл аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тусгайлан боловсруулагдсан төлөвлөгөө байхгүй байна.

Аудитын явцад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас гамшгийн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг авч үзэхэд төлөвлөгөөнд хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар тусгагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөгүй байгаа нь ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй, салбар дундын зохицуулалтгүй байгааг харуулж байна.

Иймд аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагын салбар дундын зохицуулалтыг тусгасан, хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах нь зүйтэй байна.

1.3. Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандарт, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдахгүй байна.

1.3.1. Аймгийн хэмжээнд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын шийдвэрлэлт хангалтгүй, хүнсний тухай хуулийн 6.2, 6.3, 6.5 дахь заалтууд хэрэгжихгүй байна.

Хүнсний тухай хуулийн 6.2¹-т стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална гэж заасан боловч одоог хүртэл батлагдан гараагүй байна.

Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмын төслийн 2.1-д “Нөөцөд малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, цэвэр ус хамаарна.” гэж заасан байна. Тус журмын төслөөр эдгээр бүтээгдэхүүнд улирлын нөөц бүрдүүлнэ гэж нийтэд нь заасан боловч Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан байна. Аймгийн хэмжээнд энэхүү журмын дагуу үйлдвэрийн шаардлагыг хангасан цех, аж ахуйн нэгж байхгүй бөгөөд улсын хэмжээнд 7 томоохон сүүний үйлдвэр л тус шаардлагыг хангаж, мөнгөн урамшуулал авч байна.

Махны нөөц бүрдүүлэх түр журам хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд буюу 2012-2013 онд Дорнод аймагт махны нөөц бүрдүүлж ажилласан ч сүүлийн жилүүдэд /2014-2021 он хүртэл/ хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх, зарцуулах журам батлагдан гараагүйтэй холбогдуулан махны нөөц бүрдүүлэх ажил хийгдээгүй байна. Өмнөговь аймгийн хувьд 2018 онд ИТХ-ын тогтоолоор дамжуулан “Махны нөөц бүрдүүлэх, худалдан борлуулахад тавих техникийн шаардлага: MNS 1161:2002 MNS 1161:2002” стандартад нийцүүлэн махны нөөц бүрдүүлж ажилласан байна. /Эх сурвалж: <http://www.omnogovi.gov.mn/i/409/>

Иймд Хүнсний тухай хуулийн 6.3², 6.5³ дахь заалтууд хэрэгжихгүй байна.

1.3.2. Лабораторийн үйл ажиллагаа тогтмол ажиллаж байгаа хэдий ч тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хүчин чадал өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй байна.


Аймгийн МХГ-ын дэргэдэх нэгдсэн итгэмжлэгдсэн лаборатори нь химийн чанар болон хор судлал, үр, хорио цээр, ургамлын өвчин, нян судлал, хөгц мөөгөнцрийн шинжилгээг сүүлийн 3 жилд /2019-2021 он/ дунджаар 1370 сорьцод /дээжид/ 3500 үзүүлэлтээр шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Дүрслэл 1. “Сорьц, үзүүлэлтийн харьцуулсан шинжилгээ”

¹ 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

² 6.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

³ 6.5.Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.



МХГ-ын дэргэдэх лаборатори нь 2009 онд 45 нэр төрлийн бүтээгдэхүүнд 195 үзүүлэлтээр итгэмжлэгдэж байсан бол 2021 онд 95 нэр төрлийн бүтээгдэхүүнд 430 үзүүлэлтээр итгэмжлэгдсэн байна.

Хүснэгт 1. “Лабораторийн хөрөнгө оруулалт 2017-2021”

2017-2021 онуудад нийт газрын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн 89,1 сая төгрөгийн санхүүжилтээр тоног, төхөөрөмж, эдлэл хэрэгслүүдийг шинэчилсэн байна. Цаашид 350.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн хэрэгцээ шаардлага үүссэн байна.

№	ОН	ҮНЭ, ӨРТӨГ
1	2017	12.7 сая
2	2018	12.4 сая
3	2019	14.4 сая
4	2020	12.9 сая
5	2021	36.7 сая

Тус газрын итгэмжлэгдсэн сорилтын нэгдсэн лаборатори нь 2021 оны 09 дүгээр сарын байдлаар цахилгаан, дулаан, усан хангамжийн төвлөрсөн системд холбогдсон, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, лабораторийн зориулалтаар тохижуулсан 180.5 м.кв талбайтай 13 өрөө тасалгаанд сорилт шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж байгаа боловч өрөө тасалгаанууд “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандартын болон итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал:

- Дулааны улиралд сорилт шинжилгээ хийгддэг өрөө тасалгаануудын дээврээс цас, борооны ус гоожиж, дахин засварлах боломжгүй болсон байна.
- Хүйтэн сэрүүний улиралд бүх өрөө тасалгааны халаалтын систем доголдож, халаалтын хувьд 8-13 градус хүрч байгаа нь сорилт, шинжилгээ хийх боломжгүй байдал үүссэн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2022 он хүртэл МХГ-ын лабораторийн шинэ барилга баригдаж байгаа боловч одоогийн лаборатори нь зориулалтын барилга биш учраас MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагын дагуу сорилт шинжилгээ хийхэд хүндрэлтэй, бодис урвалж хадгалах өрөө тасалгаанууд дутагдалтайн улмаас шинжилгээний эцсийн хариу буруу гарах эрсдэл үүсэж байна. Тухайлбал: Хүнсний хими, хүнсний нян судлалын шинжилгээг гадаад орчны шинжилгээтэй хамт нэг өрөөнд хийх, химийн бодис урвалж болон нян судлалын шинжилгээний тэжээлт орчныг шинжилгээний өрөөнд хадгалж байгаа нь хадгалалтын нөхцөл зөрчигдөж, улмаар тусгай зориулалтын өрөөнд хадгалаагүйгээс чанар алдагдаж, шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

МХГ-ын нэгдсэн лабораторийн тулгамдсан асуудал:

Бид аудитын явцад МХГ-ын нэгдсэн лабораторийн эрхлэгчээр ажиллаж байсан иргэнтэй утсаар ярилцлага хийсэн бөгөөд дараах асуудлууд өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна. Үүнд:


- Лабораторид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслүүд стандартын шаардлагыг хангахгүй болсон бөгөөд нарийвчилсан шинжилгээ хийж чаддаггүй. Сорьц,

- дээжид сүүлийн үеийн оношлуураар шинжилгээ хийхэд төсөө, санхүүгийн асуудал тулгардаг. Тоног төхөөрөмжийг шинэчлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн.
- Шинээр гарч буй хүнсний бүтээгдэхүүний дээжийг улсын байцаагч бүр авч шинжилгээнд хамруулж чаддаггүй. Учир нь байцаагч нар төлөвлөгөөт хяналт шалгалтаасаа хэтэрдэггүй. Нэмж хийгдэж байгаа шинжилгээ нь зөвхөн иргэний гомдол, мэдээллийн дагуу дээж авч шинжлэх асуудал байдаг. Дээжийг нэг удаа гэхэд 40 гаруй сорьцод шинжилгээ хийхгүй бол 5, 10 дээжид шинжилгээ хийхэд зардал их гардаг.
 - Мэргэшсэн боловсон хүчний цалин, нийгмийн хангамжийг сайжруулах замаар тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байна.

1.3.3. Аймгийн хэмжээнд хүнсний дотоодын болон импортын зохистой харьцаа хангагдахгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”, аймгийн статистикийн жил бүрийн гаргасан хүн амын тоонд үндэслэн дараа оны хүн амын хүнсний жишиг хэмжээг жил бүр гаргадаг.

Дүрслэл 2. “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжийн судалгаа”



Эх сурвалж: Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, 2020 оны жилийн эцсийн статистик мэдээ/

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамжийг 2020 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнүүд 100.0 хувь импортоос хамаарч байна. Тухайлбал: Гурил, махны хангалт дотоодын зах зээлийг 100.0 хувь хангаж байгаа бол гурилан бүтээгдэхүүний 14.9, сүү, сүүн бүтээгдэхүүний 78.4, төмсний 64.3, хүнсний ногооны 12.3 хувийг тус тус хангаж байгаа бол үлдсэн 77.7 хувийг /буурцагт ургамал, жимс, жимсгэнэ, өндөг, ургамлын тос, цөцгийн тос, сахар, чихрийн зүйл/ өөр аймгийн дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн болон импортын хүнсний ногоогоор хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангасан байна.

Дээрх статистик тоон үзүүлэлтээс харахад дотоодын үйлдвэрлэл болон импортын зохистой харьцаа хангагдахгүй байна. Учир нь импортоос хамаарч байгаа бүтээгдэхүүний шалтгаан нөхцөл нь дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах дэмжлэгийг хэрэгцээ, хангамж, нөөцийн судалгаан дээр үндэслэж олгоогүй байгаагаас дотоодын үйлдвэрлэл тогтвортой явагдахгүй байна.

1.3.4. Импортлогч аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний стандартыг мөрдүүлэх, хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах замаар дотоодын үйлдвэрлэгчдэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Хүнсний импортын бүтээгдэхүүн дэх чанарын удирдлага, хяналт баталгаажуулалт:

Аймгийн хэмжээнд 2019-2021 онуудад ОХУ-ын Эрэнцав хилийн боомтоор ихэвчлэн улаан буудай, үрийн улаан буудай, зарим хүнсний чихэр, жимс, БНХАУ-ын Баянхошуу боомтоор хүнсний нарийн ногоо импортлогдсон байна.

Импортын хүнсний бүтээгдэхүүнд чанарын удирдлага, хяналт баталгаажуулалт хийж буй мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийн шинжилгээг дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2. “Импортын бүтээгдэхүүнд хяналт хэрэгжүүлдэг байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ”

№	Хамаарал бүхий байгууллагууд	Чиг үүрэг	Процесс	Хүнсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйл, эрсдэл
1	Мэргэжлийн хяналтын газар	- Экспорт, импортын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хилийн хорио цээрийн хяналт тавих - Экспортоор гаргах, импортоор оруулж ирэх ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хилийн хорио цээрийн хяналт тавих - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйгээр хангах, заавар зөвлөгөө өгөх - Хариуцсан чиглэлээр холбогдох дүгнэлт, мэдэгдэл гаргах	Нэгдүгээрт импортын мэдэгдэл буюу бүтээгдэхүүнийг орж ирэхээс өмнө ургамлын гадаад хорио цээр /гадаад улс орноос хүн, малын гоц халдварт өвчин дамжин орж ирэх эрсдэл/ байгаа эсэх, Хоёрдугаарт бүтээгдэхүүн орж ирэх явцад бордооны найрлага стандарт, нормт хэмжээнд байгаа эсэхийг нэгдсэн лабораторид шинжилсний үндсэн дээр хилээр нэвтрүүлдэг байна.	- БНХАУ-д үйлдвэрлэсэн чихэр, чавга, зайрмаг гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний бүтээгдэхүүнийг 2019 оноос өмнөх жилүүдэд нууцаар оруулж ирж байсан. Сүүлийн жилүүдэд ажиглагдахгүй байгаа ч цаашид орж ирэх эрсдэлтэй байна. - Хилээр орж ирж байгаа хүнсний ногоонууд нь БНХАУ-ын Хорио цээрийн хяналт баталгаажуулалтын байгууллагын хүчин төгөлдөр шинжилгээний бичигтэй байна гэж журамд заасан боловч сүүлийн 2 жилд бичиггүй орж ирж байна. Энэ нь наймаа эрхлэгч иргэд нь баталгаагүй газраас буюу жижиглэн зах, иргэдийн гар дээрээс шууд худалдан авалт хийж байгаатай холбоотой байна. - Авто замын хилээр /Эрэнцав, Баянхошуу боомт/ хүнсний бүтээгдэхүүн оруулж ирж байгаа аж ахуйн нэгжүүд нь зориулалтын /хөлдөөгчтэй, битүүмжлэлтэй/ тээврийн хэрэгслээр зөөвөрлөөгүйгээс хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хангагдахгүй зэрэг эрсдэлүүд үүссээр байна.
2	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Импортын бүтээгдэхүүнд хяналт, баталгаажуулалт хийгддэггүй. Зөвхөн экспортын хүнсний бүтээгдэхүүнд /загас, дайвар бүтээгдэхүүн/ тохирлын гэрчилгээ олгогддог.	-	-
3	Хүнс, хөдөө, аж ахуйн газар	Хүнсний бүтээгдэхүүний импортод хяналт, баталгаажуулалт хийгддэггүй.	-	-

Чиг үүргийн шинжилгээнд тусгагдсанаас үзвэл хүнсний импортын бүтээгдэхүүнд Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хүнс, хөдөө, аж ахуйн газраас чанарын хяналт, баталгаажуулалт хийгддэггүй байна.

Харин Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт, баталгаажуулалтыг чиг үүргийн хүрээнд хийсэн байна. Эрсдэлд дурдагдсанаар хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүнсний зарим бүтээгдэхүүн орж ирэх эрсдэлийг үүсгэсээр байна.

Мөн БНХАУ-ын Хорио цээрийн хяналт баталгаажуулалтын байгууллагын шинжилгээний бичиггүй орж ирэх, аж ахуйн нэгж, иргэд нь зориулалтын тээврийн хэрэгслээр хүнсний ногоо, хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхгүй байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Иймд цаашид хилийн хяналтыг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэж буй аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний стандартыг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Дотоодын үйлдвэрлэл дэх чанарын удирдлага, хяналт баталгаажуулалт:

Дотоодын хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт, баталгаажуулалт хийдэг байгууллагуудын чиг үүргийг дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 3. “Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд хяналт хэрэгжүүлдэг байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ”

№	Хамаарал бүхий байгууллагууд	Чиг үүрэг	Процесс	Хүнсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйл, эрсдэл
1	Мэргэжлийн хяналтын газар	- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт, органик хүнс, баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгололтын байдалд хяналт тавих - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавих - Хүнсний болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, татан авах үйл ажиллагаанд хяналт тавих - Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эхлэхэд урьдчилсан хяналт хийж, дүгнэлт гаргах - Хүнсний үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж, ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэх эд зүйлс стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь холбогдох техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт, органик хүнс, баяжуулсан хүнсний үйлдвэрлэл, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих	- Эрсдэлд их, дунд эрсдэлтэй объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах - Төлөвлөгөөнд тусгагдаагүй объект, аж ахуйн нэгж, газруудад урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх - Зөвлөн туслах - Зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	- Төлөвлөгөөт хяналт, шалгалтад аж ахуйн нэгж, үйлдвэр, газрууд бүрэн хамрагдахгүй байх - Шинжилгээнд хамруулаагүй, тохирлын гэрчилгээ аваагүй, баталгаажуулаагүй хагас боловсруулсан бүтээгдэхүүн /бууз, банш, хэрчсэн гурил гэх мэт/ үйлдвэрлэх нь чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх - Ахуйн нөхцөлд үйлдвэрлэл эрхэлж буй иргэдэд ямар байгууллага хяналт тавих нь тодорхойгүй байх - Цахим үйлдвэрлэл /цахимаар хоол, хүнс худалдаалах/ эрхэлж байгаа иргэдэд тавих хяналт хязгаарлагдмал байх - Хяналт, шалгалт хийхэд үл мөрийн мөрдөн тогтоолт хийх чиг үүрэг учир дутагдалтай байх.
2	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	- ААН-үүдэд хүнсний стандартыг олгох - Үйл ажиллагаагаа стандартын дагуу явуулж байгаа ААН-үүдэд тохирлын гэрчилгээ олгох	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зарж борлуулах ААН-үүд тохирлын гэрчилгээ авч байж үйл ажиллагаа явуулна.	
3	Хүнс, хөдөө, аж ахуйн газар	- Чанарын удирдлага, хяналт баталгаажуулалт хийгддэггүй. Зөвхөн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд зөвлөгөө, мэдээлэл өгөх	-	

Чиг үүргийн шинжилгээнээс харахад Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дотоодын үйлдвэрлэл эрхчлэгчдийн үйл ажиллагаанд чанарын хяналт, баталгаажуулалт хийдэггүй байна.

Стандарт, хэмжилзүйн хэлтэс нь чиг үүргийн хүрээнд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгож, баталгаажуулалт хийх чиг үүрэгтэй байна.

Мэргэжлийн хяналтын газар нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, газруудад хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын хувьд төлөвлөгөөт хяналт, шалгалтад хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдэд урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, хяналт шинжилгээний ажлууд хийгддэг ч энэ чиглэлийн бүх аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн хяналт, шалгалтад бүрэн хамруулахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Мэргэжлийн байгууллагын зүгээс хяналт, шалгалт хийх тухайгаа шалгагдагч аж ахуйн нэгж, байгууллагад 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ⁴ гэсэн заалт нь ул мөрийн мөрдөн тогтоолт хийх чиг үүрэг үнэн зөвөөр хэрэгжихэд учир дутагдалтай байна. Мөн хяналт шалгалтын явцад аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч буй үнэлгээний хуудас нь Улаанбаатар хот, аймаг, суманд /том, жижиг үйлдвэрийн хувьд/ ижил маягтаар дүгнэгдэж байгаа нь бодлогын түвшинд буюу стандарт, журамд өөрчлөлт оруулах шаардлагатайг харуулж байна.

Гэрийн буюу ахуйн нөхцөлд хагас боловсруулсан /бууз, банш, хэрчсэн гурил гэх мэт/ бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэдийн хувьд бүтээгдэхүүндээ лабораторийн шинжилгээ хийлгээгүй, баталгаажуулалт, тохирлын гэрчилгээ авалгүй шууд худалдан борлуулж байгаа нь хүнсний чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Ахуйн нөхцөлд үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийн гэрээр очиж шалгалт хийх эрх зүйн зохицуулалт СХХ, МХГ-ын чиг үүрэгт байхгүй учраас тухайн иргэдэд чиглэсэн хяналт, шалгалтыг зохион байгуулдаггүй байна. Харин Мэргэжлийн байгууллагуудын зүгээс /МХГ, СХХ/ цех, аж ахуйн нэгжийн зөвшөөрөлтэй болсны үндсэн дээр бүтээгдэхүүнээ шинжилгээнд хамруулах, баталгаажуулалт хийлгэж, улмаар тохирлын гэрчилгээ авах талаар мэдэгдэл хүргүүлж, чанар, стандартын шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг дамжуулан худалдаалахгүй байх талаар дэлгүүр, аж ахуйн нэгжүүдэд албан шаардлагыг хүргүүлсэн боловч тухайн зөрчил бүрэн арилаагүй байна.

Мөн цахим үйлдвэрлэл /цахимаар хоол түгээх, хүнс худалдаалах/ эрхлэлтийг хянах хууль, журмын зохицуулалт байхгүйгээс хэрэглэгчид баталгаатай хүнсээр хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэсээр байна.

1.3.5. Хүнсний сүлжээний бүх үе шатны хяналт, баталгаажуулалтын тогтолцоо хэрэгжих шатанд, бүртгэл, мэдээллийн тогтолцоо орон нутгийн түвшинд бүрдээгүй байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь хүнсний сүлжээний бүх үе шатны хяналтыг 2020 оноос өмнө www.khyanal.gov.mn шилэн хяналтын системээр хэрэгжүүлж, 2021 оноос www.igov.mn системийг ашиглаж эхэлсэн байна. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь хүнсний аюулгүй байдалтай холбоотой хяналт, шалгалтын мэдээллийн баазыг 2021 оны жилийн эцэст татаж оруулан ашиглаж эхлэхээр төлөвлөсөн байна.

⁴ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5¹ дүгээр зүйл. 1.2.Хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухайгаа шалгуулах этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө шуудангаар, утсаар, эсхүл биечлэн мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд шалгалт хийх байгууллагын нэр, шалгалт эхлэх ба дуусах хугацааг заана.

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны эхний хагасаас эхлэн хүнсний бүтээгдэхүүн эрхлэгчдийн баталгаажуулалтын мэдээллийг www.masm.gov.mn/Dornod сайтад байршуулж ажилласан байна.

Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар нь орон нутгийн үйлдвэрлэл, бусад улс, аймаг орон нутаг руу хүнсний импорт, экспортын мэдээллийг нэгтгэж, хэрэгцээ хангамжийг тодорхойлох зорилгоор үйлдвэрлэл эрхлэгч, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн нэгдсэн бүртгэлийн мэдээллийн тогтолцоог шинээр бий болгох шаардлага үүссэн байна.

Мөн аудитын явцад орон нутгийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бүртгэл, хэрэглээ, хэрэгцээний судалгааг авч үзэх шаардлага үүссэн бөгөөд Үндэсний статистикийн хорооны www.1212.mn цахим мэдээллийн сайт нь улсын болон хот, хөдөөгийн хүнсний хэрэглээний судалгааг гаргасан боловч аймаг, сум бүрээр тусад нь харуулсан мэдээллийн бааз байхгүй, мэдээллийн баяжилт, нарийвчлал хангалтгүй байна. Иймд орон нутгийн түвшинд хүнсний сүлжээний бүх шатны нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байна.

1.3.6. Аймгийн хэмжээнд шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байгаа бөгөөд орон нутгийн нийт зах зээлийг бүрэн хангахгүй байна.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн 2.5.5 “Инноваци нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно” гэсэн заалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3.7-д тусгаж тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг туршилт хийж, хэрэглэгчдэд хүргэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хүрээнд орон нутгийн хөрсөн ургасан химийн ямар нэг бодис хэрэглээгүй органик хүнсийг тариалах зорилт тавин сум, баг аж ахуй нэгжүүдэд дэмжлэг болгож хүлэмж, хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дугаар тушаал “*Хоногийн хоол хүнсээр авах илчлэг үндсэн шимт бодис, эрдэс бодисын зөвлөмж*”-д зааснаар жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг баримтлан ажиллаж байна.

Хүнсний хангамжийг улсын хэмжээнд тодорхойлохдоо тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулж гаргадаг байна.

ЭМЯ-ны Хоол судлалын төвөөс тогтоосон дараах гол нэр төрлийн 16 бүтээгдэхүүнийг хамруулж хүнсний хангамжийн статистик үзүүлэлтийг тооцлоо.

Үүнд: мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, сахар, чихрийн зүйл, төмс; хүнсний ногоо, буурцагт ургамал, жимс, жимсгэнэ, өндөг, ургамлын тос, цөцгийн тос зэрэг бүтээгдэхүүнүүд орж байна.

Жишсэн хүн ам. Дорнод аймгийн хэмжээнд жилийн эцсийн суурин хүн амын тоо 2020 онд 83.5 мянга, жишсэн хүн амын тоо 67.5 мянга болж, суурин хүн амын тоо

өмнөх оноос 1453 хүн буюу 1.77 хувиар, жишсэн хүн амын тоо өмнөх оноос 1148 хүн буюу 1.73 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. "Дорнод аймгийн хүн амын тоо"

Үзүүлэлт	2019	2020	Өсөлт	
			зөрүү	хувь
Суурин хүн амын тоо	82020	83473	1453	1.77
Жишсэн хүн амын тоо*	66345	67493	1148	1.73

* ҮСХ-ын тооцоолол. Тайлбар: Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар шинэчлэгдсэн.

Дорнод аймгийн хэмжээнд жишсэн хүн амын тоо

Томъёо: $ХА_{жиш} = \sum (K_a * ХА_a)$

$ХА_{жиш}$ - Тухайн жилийн жишсэн хүн амын тоо

K_a - а насны бүлгийн хүн амыг жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр

$ХА_a$ - а насны бүлгийн хүн амын тоо

Хүснэгт 5. "Дорнод аймгийн жишсэн хүн амын тоо"


Насны бүлэг	Хүйс	Жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр	2019 он		2020 он	
			Суурин хүн амын тоо	Жишсэн хүн амын тоо	Суурин хүн амын тоо	Жишсэн хүн амын тоо
1 хүртэлх нас	эр	0.34	985	335	1053	358
	эм	0.31	951	295	1057	328
1-3 нас	эр	0.44	3134	1379	3106	1367
	эм	0.41	3022	1239	2958	1213
4-6 нас	эр	0.61	2962	1807	3060	1867
	эм	0.55	2902	1596	2957	1626
7-10 нас	эр	0.76	3725	2831	3762	2859
	эм	0.69	3525	2432	3619	2497
11-14 нас	эр	1.04	2703	2811	3054	3176
	эм	0.90	2608	2347	2903	2613
15-18 нас	эр	1.13	2257	2550	2200	2486
	эм	0.95	2054	1951	2116	2010
19-29 нас	эр	1.00	6975	6975	6723	6723
	эм	0.83	6558	5443	6168	5119
30-59 нас	эр	0.99	16056	15895	16419	16255
	эм	0.77	15471	11913	15735	12116
60-аас дээш нас	эр	0.80	2525	2020	2724	2179
	эм	0.70	3607	2525	3859	2701
Нийт хүн амын тоо			82020	66345	83473	67493

Эх сурвалж:

- Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс, www.dornod.nso.mn,
- Судлаачийн тооцоолол

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ. Дорнод аймгийн хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, орон нутгийн хэмжээнд жилд нийтдээ 4680.6 тонн мах, махан бүтээгдэхүүн, 3941.6 тонн сүү, 4434.3 тонн сүүн бүтээгдэхүүн, 2463.5 тонн гурил, 4434.3 тонн гурилан бүтээгдэхүүн, 1231.7 тонн будаа, 813.0 тонн сахар, чихрийн зүйл, 2956.2 тонн төмс, 6405.1 тонн хүнсний ногоо, 985.4 тонн буурцагт ургамал, 4927.0 тонн жимс, жимсгэнэ, 492.7 тонн өндөг, 566.6 тонн ургамлын тос, 246.3 тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна. (Дүрслэл 3)

Дүрслэл 3. "Дорнод аймгийн хэмжээнд 2019, 2020 оны жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, тн"



Жишсэн хүн амын хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ өмнөх оноос 8.4-108.9 тонноор нэмэгдсэн байна. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, сүүний хэрэгцээ 41.9-108.9 тонноор нэмэгдсэн нь хамгийн өндөр өсөлттэй байна.

Хүснэгт 6. “Жишсэн хүн амын хоногийн болон жилийн хүнсний хэрэгцээ”

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ, кг	Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, тн		Зөрүү, тн
			2019 он	2020 он	
1	Малын мах	43.8	2905.9	2956.2	50.3
2	Загас	11.0	726.5	739.0	12.6
3	Шувууны мах	14.6	968.6	985.4	16.8
4	Сүү (үнээний сүү, 3.2% тос)	58.4	3874.5	3941.6	67.0
5	Цагаан идээ (тараг)	65.7	4358.9	4434.3	75.4
6	Гурил	36.5	2421.6	2463.5	41.9
7	Гурилан бүтээгдэхүүн	65.7	4358.9	4434.3	75.4
8	Төрөл бүрийн будаа	18.3	1210.8	1231.7	21.0
9	Сахар, чихрийн зүйл	12.0	799.1	813.0	13.8
10	Төмс	43.8	2905.9	2956.2	50.3
11	Хүнсний ногоо	94.9	6296.1	6405.1	108.9
12	Жимс, жимсгэнэ	73	4843.2	4927.0	83.8
13	Буурцагт ургамал	14.6	968.6	985.4	16.8
14	Өндөг	7.3	484.3	492.7	8.4
15	Ургамлын тос	8.4	557.0	566.6	9.6
16	Цөцгийн тос, 72% тослог	3.7	242.2	246.3	4.2

Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дугаар тушаал, <https://legalinfo.mn/mn/detail/12552>

Үйлдвэрлэл. Орон нутагт 2020 онд аймгийн хэмжээнд 6451.4 тонн сүү, сүүн бүтээгдэхүүн, 16681.2 тонн мах, махан бүтээгдэхүүн, 6555.5 тонн гурил, 651.1 тонн гурилан бүтээгдэхүүн, 1865.3 тонн төмс, 804.5 тонн хүнсний ногоо, 117.4 тонн өндөг үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 7. “Дорнод аймгийн хэмжээнд гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн нийт нөөц, тн”

Хүнсний бүтээгдэхүүн	2019 он			2020 он		
	Нийт нөөц, (үйлдвэрлэл + цэвэр импорт)	Үүнээс:		Нийт нөөц, (үйлдвэрлэл + цэвэр импорт)	Үүнээс:	
		Дотоодын үйлдвэрлэлт	Цэвэр импорт (импорт- экспорт)		Дотоодын үйлдвэрлэлт	Цэвэр импорт (импорт- экспорт)
Малын мах	10801.65	11410.4	- 598.55	15983.22	16681.2	-675
Загас			-10.2			-22.98
Шувууны мах						
Сүү (үнээний сүү, 3.2% тос)	6736.6	6736.6		6451.4	6451.4	
Цагаан идээ (тараг)						

Гурил	4670.1	4670.1		6555.5	6555.5	
Гурилан бүтээгдэхүүн	1187.88	1187.88		651.1	651.1	
Төрөл бүрийн будаа	1738.8		66.9	1781.8		
Сахар, чихрийн зүйл	884.12		8.32	971.9		
Төмс	1125.46	1014.6	110.86	1865.3	1865.3	
Хүнсний ногоо	678.8	643.5	35.3	812.5	804.5	8
Жимс, жимсгэнэ	11.3	0.07	11.23			
Буурцагт ургамал				65.4		65.4
Өндөг	81.1	81.1		117.4	117.4	
Ургамлын тос	398.1			485.9		
Цөцгийн тос, 72% тослог	79.6			162.0		

Эх сурвалж: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар

Томъёо: $HH_e = DY + (I - E)$

HH_e - Нийт нөөц
 DY - Дотоодын үйлдвэрлэл
 I - Импорт
 E - Экспорт

Хүснэгт 8. “Дорнод аймгийн хэмжээнд гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн хүнсний хангамж, хувиар”

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл	Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ		Хэрэглээ		Хангамжийг түвшин	
		2019	2020	2019	2020	2019	2020
		Мянган тонн				Хувь	
1	Малын мах	2905.9	2956.2	10801.7	15983.2	234.8	341.5
2	Загас	726.5	739.0				
3	Шувууны мах	968.6	985.4				
4	Сүү (үнээний сүү, 3.2% тос)	3874.5	3941.6	6736.6	6451.4	81.8	77.0
5	Цагаан идээ (тараг)	4358.9	4434.3				
6	Гурил	2421.6	2463.5	4670.1	6555.5	192.9	266.1
7	Гурилан бүтээгдэхүүн	4358.9	4434.3	1187.9	651.1	27.3	14.7
8	Төрөл бүрийн будаа	1210.8	1231.7	1738.8	1781.8	143.6	144.7
9	Сахар, чихрийн зүйл	799.1	813.0	884.12	971.9	110.6	119.6
10	Төмс	2905.9	2956.2	1125.5	1865.3	38.7	63.1
11	Хүнсний ногоо	6296.1	6405.1	678.8	812.5	10.8	12.7
12	Жимс, жимсгэнэ	4843.2	4927.0	11.3		0.2	
13	Буурцагт ургамал	968.6	985.4		65.4		6.6
14	Өндөг	484.3	492.7	81.1	117.4	16.7	23.8
15	Ургамлын тос	557.0	566.6	398.1	485.9	71.5	85.8
16	Цөцгийн тос, 72% тослог	242.2	246.3	79.6	162	32.9	65.8

Эх сурвалж: Судлаачийн тооцооллоор

Томъёо: $XX_{хувь} = \frac{HH_e}{JX_{жиш}} * 100\%$

$JX_{жиш}$ - Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ

HH_e - Нийт нөөц (хэрэглээ)

$XX_{хувь}$ - Хүнсний хангамжийн түвшин, хувь

Хүнсний хангамжийн түвшин. Хүнсний хангамжийн түвшнийг өмнөх онтой харьцуулбал мах, махан бүтээгдэхүүн 106.7 пункт, төмс 24.4 пункт, өндөг 7.1 пункт, гурил 73.3 пункт, хүнсний ногоо 1.9 пункт, төрөл бүрийн будаа 1.0 пункт, сахар, чихрийн зүйл 8.9 пункт, ургамлын тос 14.3 пункт, цөцгийн тос 32.9 пунктээр тус тус өссөн бол гурилан бүтээгдэхүүн 12.5 пункт, сүү, сүүн бүтээгдэхүүн 4.8 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй харин жимс, жимсгэнэ болон буурцагт ургамлын хангамжийн түвшин өөрчлөгдөөгүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг орон нутгийн дотоод үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 100.0 хувь, төмсөөр 64.3 хувь, гурилаар 100.0 хувь, гурилан бүтээгдэхүүнээр 15.0 хувь сүү, сүүн бүтээгдэхүүнээр 78.5 хувь, хүнсний ногоогоор 12.8 хувийг хангаж байна.

Дээрх судалгаанаас үзэхэд Дорнод аймгийн хэмжээнд 2019, 2020 онд хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний 11 нэр төрлийн бүтээгдэхүүнээр 63.1-100.0 хувь хангаж байгаа боловч, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамал гэсэн шим тэжээллэг хүнсээр иргэдийн хэрэгцээний дөнгөж 0-23.8 хувийг хангаж байна.

Иймээс орон нутгийн иргэдээ шим тэжээллэг болон органик хүнсээр хангах шаардлага зайлшгүй байгаа бөгөөд Дорнод аймагт сүүлийн 7 жилийн турш хувиараа аж ахуй эрхлэгчтэй ярилцахад зуны болон өвлийн хүлэмжид орон нутагт өөрийн гараар ургуулсан 50 гаран зүйлийн нарийн ногоо тариалж, туршиж, нутагшуулж өрхийн хэрэглээгээ хангаад зогсохгүй зорилтот зах зээлийн багахан хэсгийг хангаж байна гэсэн тодруулга өгсөн. Иймээс өөрийн хөрсөнд ургуулсан органик хүнсээр иргэдээ хангах бүрэн боломж байна.

Ингэснээр орон нутгийн үйлдвэр эрхлэгчид болон хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлыг бодлогын хэмжээнд хангаж, орон нутагт өөрийн хөрсөнд тариалсан болон үйлдвэрлэсэн химийн бордоогүй, эрүүл органик хүнсний бүтээгдэхүүнээр орон нутгийн иргэдээ хангана. Мөн орон нутгийн иргэдийн өрхийн хүнсний хэрэглээний бүтцийг өөрчилж, органик хүнсний бүтээгдэхүүний сонголтыг зах зээлд нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

1.3.7. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.14-д "Дорнод аймгийн брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг олишруулах чанарыг сайжруулахад анхаарч, сав баглаа боодлын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ" гэсэн заалтын биелэлтээр ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 2019 онд олгосон хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт ирүүлсэн "Бабуб" ХХК-ийн төслийг дэмжиж 120.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тус компани нь өөрийн нэрийн жигнэмгийн сав баглааг шинэчлэн төмөр хайрцагтай жигнэмэг Халхголын 80 жилийн ойд зориулан гаргаж мөн 30 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Ковид-19 цар тахал гарсны улмаас түүхий эдийн татан авалт удаашралтай, импортоор оруулж ирдэг сав, баглаа боодлын үнэ 20.0 хувь нэмэгдсэн нь бэрхшээл болж байна. Төслийн хэрэгжилтийг үнэлэхэд ажлын хэсгийн гишүүдийн дундаж үнэлгээгээр 90.0 хувийн үнэлгээ авсан байна.

Мөн Дорнод аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.4.7-д "Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж сав баглаа боодлын үйлдвэр байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ", 3.2.4.10-д "Дорнод брэндиг хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана" гэж тусгагдсан байна.

МХЕГ-ын нэгдсэн удирдамжаар Дорнод аймгийн хэмжээнд МХГ-аас 2021 оны 4 дүгээр сараас хийгдсэн "Нялх, балчир хүүхдийн хүнсний сав баглаа боодол, шошгод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт"-ын үр дүнд орон нутагт худалдаалагдаж байгаа хүүхдийн сүү, сүүн тэжээлийн сав, баглаа боодол, шошго нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4, 12.5-д зааснаас гадна,

Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 6.1, 6.2-д заасан мэдээллийг бүрэн тусгаж наасан байна.

Харин Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 6.3-д заасан хориглосон мэдээллийг хүүхдийн сүүн тэжээлийн шошгод тусгаагүй байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгод “энэ бүтээгдэхүүн нь хүүхдийн хоногийн шимт бодис, эрдэс, амин дэмийн хэрэгцээг дангаар хангахгүй” гэсэн анхааруулгыг сүүн тэжээлийн шошгод байршуулаагүй байна. Зарим төрлийн хүүхдийн сүүн тэжээлд нэмэлт зураг дүрс шошгод байршуулаагүй байна.

Дээрхээс үзэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн худалдааны менежерүүд Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн мэдлэг дутмаг байгаа ба хүүхдийн сүү, сүүн тэжээлийн сав, баглаа боодол, шошгын зарим мэдээлэл бүрэн тусгаагаагүй байна.

Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018-2020 онд хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгын чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйд хийсэн хяналт шалгалтыг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2015 оны 496 дугаар “Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, Засгийн газрын 2018 оны 189 дугаар “нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” тогтоол зэрэг хууль, тогтоомжийн дагуу жил бүр МХГ-ын нэгдсэн удирдамжаар хийгдсэн байна.

Хүснэгт 9. “МХГ-ын 2018-2020 оны хяналт, шалгалтын судалгааны илэрц”

2018 он	2019 он	2020 он
Судалгааны явцад 13 нэрийн цагаан, шар, ногоон, тунгалаг өнгийн хуванцар дөрвөлжин дугуй, хавтгай, төрөл бүрийн хэлбэртэй том жижиг аяга, таваг, халбага, сэрээ, хутга зэрэг 35010 ш хуванцар нэг удаагийн хэрэгсэл худалдаалж байна.	Судалгааны явцад 13 нэрийн цагаан, шар, ногоон, тунгалаг өнгийн хуванцар дөрвөлжин дугуй, хавтгай, төрөл бүрийн хэлбэртэй том жижиг аяга, таваг, халбага, сэрээ, хутга зэрэг 17560 ш хуванцар нэг удаагийн хэрэгсэл худалдаалж байна.	Урьдчилан сэргийлэх явцад: а/ нэг удаагийн өнгөгүй тунгалаг хуванцар аяга, 1 дүгээр хоолны бөөрөнхий тагтай том, жижиг таваг, дөрвөлжин таваг, халбага, сэрээ, хутга, хуванцар 0.33, 0.5мл цэвэр усны үлээдэг сав, 19 мл усны сав. б/ ногоон өнгөтэй 1 дүгээр хоолны бөөрөнхий тагтай таваг, улаан хүрэн өнгөтэй хуванцар тасалгаатай хоолны дөрвөлжин таваг, хүрэн бор өнгөтэй бөөрөнхий тасалгаатай хоолны таваг, дөрвөлжин цагаан өнгөтэй 2-р хоолны таваг, өнгө бүрийн хуванцар соруул, шар өнгөтэй халбага, сэрээ, шанага. в/ кола, кофены цаасан аяганы хуванцар цагаан, хүрэн өнгөтэй таг. г/ төрөл бүрийн нийлэг гялгар уутнууд Нийт 17 төрлийн нэг удаагийн хуванцар хоолны хэрэгсэл, 8 нэр төрлийн нийлэг уутнуудыг хамруулан шалгагдсан.

Аймгийн МХГ-аас 2018-2020 онуудад хийгдсэн хяналт шалгалт, тандалт судалгаа, урьдчилан сэргийлэх шалгалтуудад нийт давхардсан тоогоор 350 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулсан байна.

Төрийн байгууллагууд шат шатандаа жил бүрийн гүйцэтгэлийн тайландаа зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд анхаарах асуудлыг тусгасан ажлуудыг тодорхой зорилтот аж ахуйн нэгж, иргэдэд хүргэсэн байна.

Мөн зах зээлийн багтаамжаас хамаарч орон нутгийн хүнсний зориулалтын жижиг үйлдвэрүүдийн сав баглаа боодол, хаяг шошгын захиалгыг багадаа 1 сая ширхгээр үйлдвэрлэдэг бөгөөд энэ сав баглаа боодлоо ашиглаж дуусах хүртэл ахиж шинэчлэх хүндрэлтэй тул бүтээгдэхүүний шинэчлэлд тохируулан тухай бүрд нь сав боодол, хаяг шошгодоо тэр бүр шинэчлэл хийгддэггүй зөрчил гардаг байна.

Аймгийн хэмжээнд гэр хороололд амьдарч иргэдийн ундны усны савны 19.1 хувь нь шаардлага хангасан сав хэрэглэж байгаа нь маш хангалтгүй, мөн хөдөөгийн айлуудын хуванцар шанага, савны хэрэглээ буурахгүй байна.

Төрийн байгууллагууд авч хэрэгжүүлсэн ажлуудаа ямар шалгуураар үнэлсэн, ямар зах зээлийг хамарвал хангалттай үр дүн үзүүлэх, орон нутагт сав баглаа, боодлын эрүүл, зөв сонголтыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлууд зайлшгүй шаардлагатай байна. Мөн хувийн хэвшлийн үйлдвэр, худалдаа эрхлэгчид, иргэд хамгийн их анхаарах хэрэгтэй бөгөөд энэ дадал зуршлыг төлөвшүүлэх нь мөн л төрийн зөв, оновчтой, хүртээмжтэй бодлого чухал бөгөөд хэрэгжилтийг үнэлэх бодитой шалгуур хэрэгтэй байна.

Үүнд:

- Орон нутгийн удирдлагын зүгээс стандартын шаардлага хангасан савыг төсөл хөтөлбөрийн хүрээнд хангах асуудлыг шийдвэрлэх, иргэдэд хуванцар савны хор уршиг, хэрэглээний талаар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулах,
- Хүнсний зах, худалдааны төвд худалдаалж байгаа хуучин хөх савыг худалдах, улсын хилээр оруулахыг хориглох шийдвэр гаргуулах,
- Улсын хэмжээнд стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны сав үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийн талаарх мэдээллээр орон нутгийн байцаагчдыг хангах;
- Хальсан уут хэмжих орчин үеийн багаж хэрэгслээр хангах.

Ингэснээр Монгол хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, байгаль орчинд ээлтэй хүнсний зориулалтын сав баглаа, боодлын хэрэглээг өдөр тутмын хэрэглээнд хэрэглэж хэвшүүлнэ. Иргэдийн хоол хүнснээс хамаарсан өвчлөл, нас баралтыг бууруулж, эрүүл, аюулгүй хүнс сонгох боломжоор хангагдана гэж үзэж байна.

1.3.8. Аймгийн хэмжээнд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар бодлогын түвшинд оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын хүрээнд хүн амын хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнд мөн хүнсний тухай хуулийн 3.1.2-д зааснаар “хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг хэлнэ гэж заажээ.

Олон улсад улс орны хүнсний аюулгүй байдал нь тухайн улсын ядуурлын түвшинтэй ижил түвшинд байдаг гэж үздэг байна. Үүнээс авч үзвэл, Монгол улсын ядуурлын түвшин 2020 оны байдлаар 33.0 хувь байгаа нь хүнсний аюулгүй байдал 33.0 хувиар алдагдсан байх магадлалтай харагдаж байна.

Харин Дорнод аймаг 2018 оны байдлаар ядуурлын түвшин 42.5 хувь байгаа нь улсын дунджаас 14.1 хувиар, зүүн бүсийн дунджаас 5.1 хувиар илүү байна.⁵ Тэгэхээр Дорнод аймгийн хүнсний аюулгүй байдал 42.5 хувиар алдагдсан байх магадлалтай байна.

⁵ Ядуурлын үндсэн үзүүлэлт - Үндэсний статистикийн хороо – www.1212.mn

Дорнод аймгийн хүн амын тоо 2020 оны байдлаар 83087, хүн амын нягтрал 0.7 байна. Хүн амынхаа мах махан бүтээгдэхүүний хэрэгцээг 100 хувь, гурилын 100 хувь, сүү сүүн бүтээгдэхүүний хэрэгцээний 78.5 хувь, төмс, хүнсний ногооны хэрэгцээний 13-65 хувийг өөрийн үйлдвэрлэлээр бүрэн хангаж байна. Бусад гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Улаанбаатар болон Хятад улсын хилийн боомтоор дамжуулан хэрэглэж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдах, хүнсний аюулгүйд сөргөөр нөлөөлж байна. Мөн аймагт борлуулагдаж буй мах, сүү, цагаан идээний хадгалалт, тээвэрлэлт түгээлт болон хоол, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуйн нөхцөлтэй холбоотой эрүүл мэндийн эрсдэлүүд гарах магадлал өндөр байна.

Манай орны хувьд 3 сая гаруй хүн амтай, малын тоо 60 гаруй саяд хүрээд байгаа ба малын гаралтай бүтээгдэхүүн, ялангуяа махыг хоол хүнсэндээ түлхүү хэрэглэдэг онцлогтой. Одоогийн байдлаар мал аж ахуйн практикт 700 гаруй эмийг улсын бүртгэлд бүртгэн хэрэглэж байна.

Малд хэрэглэснээс тухайн эмийн үлдэгдэл хүнсний бүтээгдэхүүнээр дамжин хүний эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй байна. Иймд хүнсэнд хэрэглэж буй малын бүтээгдэхүүнийг тухай бүр лабораторийн шинжилгээнд хамруулж, чанар, аюулгүй байдлыг хангах нь нэн чухал юм.

Хүнсний аюулгүй байдалд хүнсний бүтээгдэхүүний түүхий эдээс эхлээд биологийн нэмэлт бүтээгдэхүүн хүртэл бүх үе шат хамаардаг байна.

Дүрслэл 4. “Хүнсний аюулгүй байдлын схем”



Монгол хүний хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс, аминдэмийн гол эх үүсвэр болох жимс, хүнсний ногоо бага хувийг эзэлсэн хэвээр байна.

Хүснэгт 10. “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын гинжин хэлхээ”

Орц	Үйлдвэрлэл	Гарц
Тариалалтын өмнөх логистик	Тариалалт	Тариалалтын дараах логистик
Хөрс судлал, үр суулгац, органик бордоо, ургац хамгаалал, усалгаа, хураалт	Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны эцсийн бүтээгдэхүүн	Хадгалалт, тээвэрлэлт
		Бөөний
		Жишээлбэл
		Хүнсний сүлжээ дэлгүүрүүд, их дэлгүүрүүд, нэрийн дэлгүүрүүд гэх мэт
		Хэрэглэгчдийн сонирхлын өөрчлөлт
Шат болгонд хүнсний аюулгүй байдлын зохистой стандартыг мөрдөж, хүний эрүүл мэндэд тустай органик болон шим тэжээлтэй бүтээгдэхүүний судалгаа ба хөгжүүлэлт хийгдэж байх		

Эх сурвалж: Судлаачийн санал

АИТХ-ын 2017 оны 04 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 1.3-д “Хүн амын эрүүл зохистой хооллолтыг дэмжин, хүн амын дундах жингийн илүүдэл, амин дэм, эрдэс бодисын дутагдлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах” гэсэн заалтын хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, эрүүл мэндийн байгууллагууд хамтран хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх, аюулгүй хоол хүнс сонгон хэрэглэх зөвлөмж, санамжийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулж, орон нутгийн телевиз, Jaran.mn цахим сайтад хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч ажилласан байна.

Мөн үдийн цай, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй байдалд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажлын байран дээр арга зүйн зөвлөгөөг жил бүр зохион байгуулан ажилласан байна.

Дээрхээс өөрөөр орон нутгаас хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлаар иргэдэд чиглэсэн хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлээр хийсэн тодорхой ажил байхгүй байна.

Иргэдийн хоол, хүнсний боловсролтой хамааралтай тохиолдож болох доорх өвчлөлийн шалтгаануудыг орон нутгийн хэмжээнд авч үзвэл:

Хүснэгт 11. “Дорнод аймгийн хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 2019, 2020 он, 10000 хүн амд”

Үзүүлэлт	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин
2020 он	1718.0	1295.5	847.7	576.0	249.8
2019 он	2117.2	1622.4	636.3	657.7	203.4

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд”-ийн тайлангууд, 2019, 2020 он, http://www.hdc.gov.mn/media/uploads/2021-08/Eruul_mendiin_uzuulelt_2020.pdf

Монгол улсын хэмжээнд хоол боловсруулах тогтолцооны өвчлөл нийт өвчлөлийн бүтцээр 2018 онд 16.1 хувь, 2019 онд 16.3 хувь, 2020 онд 19.4 хувь болж өссөн байна.

Дорнод аймгийн хэмжээнд хоол боловсруулах тогтолцооны өвчлөл нийт тэргүүлэх 5 өвчлөлийн бүтцээр 2019 онд 40.4 хувь, 2020 онд 36.7 хувь байна.

Хүснэгт 12. “Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10000 хүн амд”

Үзүүлэлт	2019 он			2020 он		
	Улсын дундаж	Аймгийн дундаж	Дорнод аймаг	Улсын дундаж	Аймгийн дундаж	Дорнод аймаг
Хоол боловсруулах тогтолцооны өвчний нас баралт	3.7	3.1	4.6	3.3	2.8	3.1
Зүрх-судасны тогтолцооны өвчний нас баралт	17.3	18.9	17.4	16.2	17.0	12.2
Хавдар	14.4	14.5	18.2	12.9	12.9	16.1

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд”-ийн тайлангууд, 2019, 2020 он, http://www.hdc.gov.mn/media/uploads/2021-08/Eruul_mendiin_uzuulelt_2020.pdf

Мөн нас баралтын тэргүүлэх шалтгаанаар хоол боловсруулах тогтолцооны өвчний нас баралт 10000 хүн амд 4.6 (улсын хэмжээнд 3.7), зүрх-судасны тогтолцооны

өвчний нас баралт 17.4 (улсын хэмжээнд 17.3), хавдар 18.2 (улсын хэмжээнд 14.4) байна.

Хүснэгт 13. “Дорнод аймгийн хэмжээнд хорт хавдрын өвчлөл, нас баралт, 10000 хүн амд”

Үзүүлэлт	2019 он	2020 он
Ходоодны хорт хавдрын өвчлөл	3.9	4.2
Ходоодны хорт хавдрын нас баралт	3.0	2.7
Элэгний хорт хавдрын өвчлөл	10.0	10.5
Элэгний хорт хавдрын нас баралт	9.7	8.8

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв, “Эрүүл мэндийн үзүүлэлтүүд”-ийн тайлангууд, 2019, 2020 он, http://www.hdc.gov.mn/media/uploads/2021-08/Eruul_mendiin_uzuulelt_2020.pdf

Хоол боловсруулах тогтолцоотой хамааралтай элэгний болон ходоодны хорт хавдрын өвчлөл болон нас баралтын үзүүлэлт Дорнод аймгийн хэмжээнд 2020 онд ходоодны хорт хавдрын өвчлөл улсын дунджаас 0.7, нас баралт 0.5-аар, мөн элэгний хорт хавдрын өвчлөл улсын дунджаас 3.7, нас баралт 3.9-өөр өндөр байна.

“Дорнодын ээжүүд” facebook group (27800 гишүүнтэй) дээр ээжүүдээс гэр бүлийн худалдан авалтад хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлийг тандах зорилгоор 9 дүгээр сарын 13-наас 10 дугаар сарын 20 хүртэл хугацаанд “Гэртээ хүнс худалдан авахдаа бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн хугацааг тогтмол хардаг эсэх”-ийг тодруулахад группээс 33 хандалт л авсан байна.

Эндээс үзэхэд орон нутагт ээжүүд гэр бүлдээ хүнс худалдан авахдаа бүтээгдэхүүний хадгалалт, хэрэглэх заавар, орц найрлага гэх мэт зүйлд тийм ч анхаардаггүй болох нь харагдаж байна.

Иймд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар бодлогын түвшинд оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ингэснээр ирээдүйд эрүүл зөв хүнсний хэрэглээтэй иргэнийг төлөвшүүлж өсгөх бөгөөд дунд болон урт хугацаанд органик болон шим тэжээллэг хүнсээр өрхийн хэрэглээгээ хангах дадал төлөвшсөн өрхүүд нэмэгдэхээр байна.

БҮЛЭГ 2. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1.1. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;”, 4.1.17-д “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;” гэж заасан байна.

Аудитын явцад 2018-2020 онуудыг хамруулж, хүнсний чиглэлээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийг төлөвлөхдөө хүнсний салбарын үндэсний хөтөлбөр болон аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрт үндэслэсэн эсэхийг үзлээ.

Аймгийн хэмжээнд хүнсний салбарын чиглэлээр аймгийн ИТХ-ын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, арга хэмжээнд 2018 онд 10.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2019 онд 7.0 сая төгрөгийн 1 төсөл,

арга хэмжээ, 2020 онд 47.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж батлуулсан байна.

Хүнсний салбарын ЗГ-аас батлагдан хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд 2018-2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөөгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хүнсний салбарын үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс аймгийн “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.

2.1.2. Хүнсний салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.

Хүнсний салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө Төсвийн тухай хууль тогтоомж, журамд заасны дагуу хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байх ёстой.

Аудитын явцад хөрөнгө оруулалтын хөтөлбөр, арга хэмжээнд төсвийн хөрөнгө төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлагад тодорхойлогдсон эсэхийг холбогдох баримт материалаас үзэхэд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2018 оны 10.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2019 оны 7.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2020 оны 47.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.

2.1.3. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дорнод аймагт хүнсний салбар чиглэлээр хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-аар 2018 онд 10.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2019 онд 7.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2020 онд 47.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ тус тус батлагдаж хэрэгжсэн байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй хөтөлбөр, арга хэмжээнд 2018 онд 10.0 сая төгрөгийг, 2019 онд 7.0 сая төгрөгийг, 2020 онд 46.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитын явцад үндэсний болон дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг холбогдох төсвийн гүйцэтгэлийн баримт материалаас үзэхэд аймгийн “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсөвт батлуулж хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүнсний салбарын үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018-2020 онд орон нутгийн төсвийн эх үүсвэрээр хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хөрөнгө зарцуулагдаагүй байна.

2.1.4. Аймгийн хүнсний салбарт батлагдсан дэд хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт хийгдсэн байна.

Орон нутгаас төсвөөс санхүүжүүлж буй хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”; Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь хүнсний салбарын үйл ажиллагаанд тусгайлан хяналт шалгалт хийгээгүй ч орон нутгийн төсвийн 2018, 2019 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийсэн дотоод хяналт шалгалтад хүнсний чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр төсөл, арга хэмжээг хамруулсан байна.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалт болон 2021 оны хөрөнгө оруулалтын явцад энэ оны төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг хийж байна.

Тус алба нь 2020 оны 03 сард аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018, 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бөгөөд уг хяналт шалгалтаар нийт 254.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлснээс 24.6 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 128.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 101.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

466


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
21000, Чойрбалзур, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584
2021.11.05 № 1/2166
танай _____ -ны № _____ -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

"Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийсэн аудитын төсөлтэй танилцлаа.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.


ЗАСАГ ДАРГИЙН
ОРЛОГЧ Ч.ТАНБАТ

010321663

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдаагүй байна.
2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.
3. Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зарим үндэсний хөтөлбөрүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.
4. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зарим журмууд батлагдаагүйгээс хуулийн заалтууд бүрэн хэрэгжихгүй байна.
5. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог бодлогоор зохицуулсан ч хэрэгжилт хангалтгүй байна.
6. Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилсан байна.
7. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дахин давтан гарч байна.

8. Хүнсний аюулгүй байдал алдагдах онцгой нөхцөл байдал үүсэх үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна.
9. Аймгийн хэмжээнд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын шийдвэрлэлт хангалтгүй, хүнсний тухай хуулийн 6.2, 6.3, 6.5 дахь заалтууд хэрэгжихгүй байна.
10. Лабораторийн үйл ажиллагаа тогтмол ажиллаж байгаа хэдий ч тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хүчин чадал өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй байна.
11. Аймгийн хэмжээнд хүнсний дотоодын болон импортын зохистой харьцаа хангагдахгүй байна.
12. Импортлогч аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний стандартыг мөрдүүлэх, хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах замаар дотоодын үйлдвэрлэгчдэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
13. Хүнсний сүлжээний бүх үе шатны хяналт, баталгаажуулалтын тогтолцоо хэрэгжих шатанд, бүртгэл, мэдээллийн тогтолцоо орон нутгийн түвшинд бүрдээгүй байна.
14. Аймгийн хэмжээнд шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байгаа бөгөөд орон нутгийн нийт зах зээлийг бүрэн хангахгүй байна.
15. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөгүй байна.
16. Аймгийн хэмжээнд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар бодлогын түвшинд оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.
17. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн байна.
18. Хүнсний салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн байна.
19. Хүнсний салбарын дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
20. Аймгийн хүнсний салбарт батлагдсан дэд хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт хийгдсэн байна.

Аудитаар нийт 10 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 8 саналыг хүргүүлээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй үндэсний стандартуудыг шинэчлэх.
2. Сүүний урамшуулал олгох журамд орон нутгийн сүүний үйлдвэрийн тавих шаардлагыг тусад нь зааж өгөх.
3. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг батлах.
4. Баяжуулах хүнсний жагсаалтыг батлах.
5. Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлтэй холбогдсон журмыг батлах.
6. Нийгмийн цахим сүлжээ болон сошиалаар явуулдаг онлайн худалдааны талаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заалт оруулах, журам боловсруулж, хяналтын тогтолцоотой болгох.
7. Хүнсний чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан түрээслэгч, түрээслүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулсан журам гаргах, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд тусгах.
8. Хүнсний сүлжээний бүх шатны нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн болон ЗДТГ, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын удирдлагуудад зөвлөж байна. Үүнд:

1. Хууль, журмыг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн дагуу тайлагнах, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах.
2. Орон нутагт хүнсний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус, хувийн хэвслүүдийн ажлын уялдаа холбоог судалгаанд суурилан бодлогын түвшинд оновчтой тусгаж хэрэгжүүлэн дүгнэж байх.
3. Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр илэрсэн зөрчлийг засаж залруулах, давтан гаргуулахгүй байх талаар оновчтой үйл ажиллагаа хэрэгжүүлж үр дүнг дээшлүүлэх.
4. Хүнсний аюулгүй байдал алдагдах онцгой нөхцөл байдал үүсэх үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлах.
5. Хүнсний тухай хуулийн 6.2, 6.3, 6.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.
6. Лабораторийн тоног төхөөрөмжийн асуудлыг өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, шинэ барилга байгууламжийн асуудлыг төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оруулах.
7. Дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих замаар импортын бүтээгдэхүүний зохистой харьцааг хангах.
8. Хилийн хяналтыг сайжруулах замаар хүнсний бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний стандартыг мөрдүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, дотоодын үйлдвэрлэгчдэд тавих хяналтыг сайжруулах.
9. Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд бодлогоор:

- Хүнсний нарийн ногоо болон жимс, жимсгэнийн мод тариалалтын зориулалтаар газар олголтыг хийх
 - Орчин үеийн усалгааны системээр хангах
 - Мэргэжлийн агрономичийг сургах, орон нутагт ажиллуулах
 - Өвөл зуны хүлэмжийн тариалалт болон агропарк байгуулах (Тухайлбал: Өмнөговь аймгийн агропаркад 13 нэр төрлийн нарийн ногоо ургуулдаг байна.)
10. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын сайжруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 20

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010017

